**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТАМГЫН ГАЗАР**

# “МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ’’-ИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар хот
2025 он

## АГУУЛГА

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл''-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд хийсэн дүн шинжилгээ ............................ **Error! Bookmark not defined.**

Дүн шинжилгээний зорилго, арга зүй............................................... **Error! Bookmark not defined.**

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн ........................................ **Error! Bookmark not defined.**

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт ............ **Error! Bookmark not defined.**

Гурав. Үр дүнгийн шинжилгээ .......................................................... **Error! Bookmark not defined.**

Дөрөв. "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгасан зорилго, зорилт хүрэх үр дүн нь урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнг хангасан эсэх.............................................................................................. **Error! Bookmark not defined.**

Тав. "Монгол Улсыг 2021-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" нь зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хангасан болон бүрэн хэрэгжсэн эсэхэд хийсэн дүн шинжилгээ .......................................................................................... **Error! Bookmark not defined.**

Зургаа.Санхүүжилтийн гүйцэтгэл: .................................................... **Error! Bookmark not defined.**

Долоо. Дүгнэлт ........................................................................................................... 26

Зөвлөмж...................................................................................................................... 28

Хавсралт 1 .................................................................................................................. 27

## “МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ’’-ИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Эрх зүйн үндэслэл**: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийг үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт, 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг баталсан.

Тус баримт бичигт Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван, аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот, гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээг тодорхойлж тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1, 117.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн 2024 оны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийв.

### Зорилго, арга зүй

Дүн шинжилгээний зорилго нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’ нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн эсэх, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг болон зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5 дахь хэсэгт заасан урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрсэнийг тодорхойлж, цаашид анхаарах асуудлаар дүгнэлт, санал гаргах, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл өгөх, улмаар хөгжлийн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

Дүн шинжилгээ, үр дүнгийн шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн 2024 оны зорилго, зорилтын хэрэгжилтийг тус журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу үнэлсэн болно.

### НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд үндсэн чиглэлд тусгагдсан 9 зорилго, 47 зорилтыг хангахад чиглэсэн 243 арга хэмжээний хэрэгжилт дунджаар 52.6 хувь байна. Энэ нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас уг үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 65.0 хувь гэж үнэлснээс 12.4 нэгж хувиар буурсан үнэлгээтэй байна.

Үнэлгээ буурахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийг хэрэгжүүлэхээр тусгагдсан нийт 243 төсөл, арга хэмжээний үр дүнг бүрэн тайлагнаагүй, аргачлалын дагуу үнэлээгүй, зарим санхүүжилт батлагдаагүй, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь, шалгуур үзүүлэлтийг хангаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй, авсан арга хэмжээ, үр дүнг тайлагнаагүй, зорилтот түвшиндээ

бүрэн хүрээгүй, гүйцэтгэл дутуу зэрэгтэй холбоотой арга хэмжээг аргачлалын[1] дагуу үнэлсэн нь нөлөөлсөн.

Хүснэгт 1. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн хэрэгжилт (үндсэн 9 бодлогоор)

| Д/д | Бодлого | Хэрэгжилтийн дундаж хувь | |
|---|---|---|---|
| | | Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үнэлгээ | УИХ-ын Тамгын газрын үнэлгээ |
| 1 | Үндэсний нэгдмэл үнэт зүйл | 51.9 | 31.9 |
| 2 | Хүний хөгжил | 65.9 | 57.3 |
| 3 | Амьдралын чанар ба дундаж давхарга | /66.3 | 50.7 |
| 4 | Эдийн засаг | 72.6 | 44.0 |
| 5 | Засаглал | 55.2 | 49.6 |
| 6 | Ногоон хөгжил | 63.9 | 56.7 |
| 7 | Амар тайван, аюулгүй нийгэм | 81.7 | 60.4 |
| 8 | Бүс, орон нутгийн хөгжил | 61.7 | 61.7 |
| 9 | Улаанбаатар ба дагуул хот | 57.1 | 52.9 |
| **Дундаж үнэлгээ** | | **65.0** | **52.6** |
| | | **12.4 нэгж хувиар буурсан** | |

*Эх сурвалж: “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”*

Зураг 1. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн хэрэгжилтийн харьцуулалт (үндсэн 9 бодлогоор)




“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн үндсэн 9 бодлогоос Бүс, орон нутгийн бодлого, Амар тайван, аюулгүй нийгэм бодлого нь бусад бодлогоос илүү хувиар хэрэгжсэн бол Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Эдийн засаг, Засаглал бодлого нь 31.9-49.6 хувь буюу бусад бодлоготой харьцуулахад хэрэгжилт нь бага хувьтай байна.

[1] Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлал

Хүснэгт 2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн 2024 оны хэрэгжилт ( хэрэгжилтийн хувиар)

| Д/д | Бодлого | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | Дундаж үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100.0 | 90.0 | 70.0 | 50.0 | 30.0 | 0 | |
| 1 | Үндэсний нэгдмэл үнэт зүйл | 16 | 0 | 0 | 0 | 9 | 2 | 5 | 31.9 |
| 2 | Хүний хөгжил | 49 | 1 | 6 | 15 | 20 | 4 | 3 | 57.3 |
| 3 | Амьдралын чанар ба дундаж давхарга | 27 | 0 | 6 | 4 | 5 | 10 | 2 | 50.7 |
| 4 | Эдийн засаг | 35 | 3 | 3 | 4 | 6 | 13 | 6 | 44.0 |
| 5 | Засаглал | 25 | 0 | 3 | 6 | 8 | 5 | 3 | 49.6 |
| 6 | Ногоон хөгжил | 18 | 0 | 5 | 2 | 5 | 6 | 0 | 56.7 |
| 7 | Амар тайван, аюулгүй нийгэм | 23 | 0 | 2 | 10 | 9 | 2 | 0 | 60.4 |
| 8 | Бүс, орон нутгийн хөгжил | 29 | 1 | 3 | 14 | 7 | 3 | 1 | 61.7 |
| 9 | Улаанбаатар ба дагуул хот | 21 | 1 | 4 | 2 | 6 | 7 | 1 | 52.9 |
| | **Нийт** | **243** | **6** | **32** | **57** | **75** | **52** | **21** | **52.6** |

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн нийт арга хэмжээний 2.5 хувь буюу 6 арга хэмжээ “үр дүнтэй’’, 36.6 хувь буюу 89 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 52.3 хувь буюу 127 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 8.6 хувь буюу 21 арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

Зураг 2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн хэрэгжилт, үнэлгээний ангиллаар




## 2.1.Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын хүрээнд 5 зорилт, 16 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 31.9 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Энэ нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг 51.9 хувь гэж үнэлснээс 20 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм.

Үнэлгээ буурахад 13 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тайланд тусгаагүй, арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан, зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хангаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй, арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, гүйцэтгэл дутуу зэрэгтэй холбоотой арга хэмжээг аргачлалын[2] дагуу үнэлэхэд дээрх шалтгаанууд нөлөөлсөн.

[2] Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлал

Хүснэгт 3. Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | ЗГХХГ үнэлгээ, хувь | УИХТГ үнэлгээ, хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | |
| 1.1 | Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ. | 5 | - | - | - | 4 | 1 | - | 70.0 | 46.0 |
| 1.2 | Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ. | 4 | - | - | - | 2 | - | 2 | 42.5 | 25.0 |
| 1.3 | Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ. | 2 | - | - | - | 1 | 1 | - | 60.0 | 40.0 |
| 1.4 | Үнэт зүйлийн болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааг салбар бүрээр хийж, нийтийн хүртээл болгоно. | 2 | - | - | - | 1 | - | 1 | 60.0 | 25.0 |
| 1.5 | Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ. | 3 | - | - | - | 1 | - | 2 | 23.3 | 16.7 |
| **Нийт** | | **16** | **-** | **-** | **-** | **9** | **2** | **5** | **51.9** | **31.9** |

*(Эх сурвалж: "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын хүрээнд дэвшүүлсэн 5 зорилтын 16 арга хэмжээнээс **11** арга хэмжээ "эрчимжүүлэх шаардлагатай", **5** арга хэмжээ "үр дүнгүй" хэрэгжсэн байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

"Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 30-70 хүртэл хувийн хэрэгжилттэй 11 арга хэмжээ дараах хүчин зүйлээс шалтгаалсан байна. Үүнд:

- хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг тайланд тусгаагүй; /1.3.2-30%, 1.1.1, 1.1.2, 1.1.4, 1.1.5, 1.2.2, 1.3.1, 1.4.2, 1.5.2-50%/
- арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан**;** /1.1.3-30%, 1.2.1-50%/

"Үр дүнгүй" буюу 0-30 хүртэл хувийн хэрэгжилттэй 5 арга хэмжээ дараах хүчин зүйлээс шалтгаалсан байна. Үүнд:

- хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг тайланд тусгаагүй; /1.2.3, 1.2.4, 1.5.1, /
- арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан**;** /1.4.1, 1.5.3/

Тухайлбал, 1.4.1-д “үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулах” арга хэмжээг 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2024 онд “Монголын эзэнт гүрний өв: Бичгийн эх сурвалж ба эд өлгийн соёл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, 30 хувийн хэрэгжилттэй гэж тайланд тусгажээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлд соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог тодорхой тусгасан бөгөөд тайланд “үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгох” талаар тусгаагүй тул бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлж байгаа буюу 50 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн.

## 2.2.Хүний хөгжил

Хүний хөгжил бодлогын хүрээнд 7 зорилт, 49 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 57.3 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг 65.9 хувь гэж үнэлснээс 8.6 нэгж хувиар буурсан.

Үнэлгээ буурахад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан, зохион байгуулалт удаашралтай, аргачлалын дагуу үнэлээгүй, арга хэмжээний агуулгаас өөр арга хэмжээ тайлагнасан, үр дүн тодорхойгүй зэрэг нөлөөлсөн.

Хүснэгт 4. Хүний хөгжил бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | ЗГХХГ үнэлгээ, хувь | УИХТГ үнэлгээ, хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100.0 | 90.0 | 70.0 | 50.0 | 30.0 | 0.0 | | |
| 2.1 | Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | 12 | - | 3 | 6 | 3 | - | - | 73.3 | 70.0 |
| 2.2 | Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ. | 8 | - | - | 2 | 5 | 1 | - | 57.5 | 52.5 |
| 2.3 | Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ. | 5 | - | 1 | 1 | 2 | - | 1 | 70.0 | 52.0 |
| 2.4 | Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, инновацийн тогтолцоог бүрдүүлнэ. | 9 | - | 2 | 2 | 4 | - | 1 | 73.3 | 57.8 |
| 2.5 | Эрүүл баталгаат орчныг бий болгоно. | 6 | - | - | - | 4 | 1 | 1 | 45.0 | 38.3 |
| 2.6 | Хөдөлмөрийн зах зээлийн хөлс, урамшууллын тогтолцоог бэхжүүлнэ. | 5 | 1 | - | 2 | 1 | 1 | - | 72.0 | 64.0 |
| 2.7 | Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ. | 4 | - | - | 2 | 1 | 1 | - | 62.5 | 55.0 |
| **Нийт** | | **49** | **1** | **6** | **15** | **20** | **4** | **3** | **65.9** | **57.3** |

*(Эх сурвалж: “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Тус бодлогын хүрээнд дэвшүүлсэн 7 зорилт, 49 арга хэмжээнээс 1 арга хэмжээ “үр дүнтэй”, 21 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 24 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” , 3 арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

“Үр дүнгүй” буюу 0 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ дараах хүчин зүйлээс шалтгаалсан байна. Үүнд:

- 2.3.3.Залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирна-хариуцан хэрэгжүүлэх байгууллагын уялдаа холбоо сул;
- 2.4.9.Шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацын төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулна - арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээний албан ёсны болон захиргааны маягтыг баталсантай холбоотой хийсэн ажлыг тайлагнасан байх бөгөөд шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг хэрхэн ашиглаж, хэрэглээнд нэвтрүүлж байгаа талаар зорилт, арга хэмжээний хүрээнд хийсэн ажлыг тайлагнаагүй;
- 2.5.3-т тусгагдсан “Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.” арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй буюу “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулалтын шатанд байна.

## 2.3.Амьдралын чанар ба дундаж давхарга

Амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын хүрээнд 6 зорилт, 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба дээрх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 50.7 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай’’ байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг нь 66.3 хувь гэж үнэлснээс 15.6 нэгж хувиар үнэлгээ буурсан нь 20 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тайланд тусгаагүй, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн, холбогдох шийдвэр боловсруулах шатанд байгаа зэрэг зорилтот үр дүнд хүрээгүй байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нөлөөлсөн байна.

Хүснэгт 5. Амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | ЗГХХГ үнэлгээ, хувь | УИХТГ үнэлгээ, |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100.0 | 90.0 | 70.0 | 50.0 | 30.0 | 0.0 | | |
| 3.1 | Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ. | 5 | - | 1 | 3 | - | 1 | - | 88.0 | 66.0 |
| 3.2 | Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ. | 4 | - | - | - | 1 | 2 | 1 | 27.5 | 27.5 |
| 3.3 | Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж | 5 | - | 1 | - | 2 | 2 | - | 70.0 | 50.0 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | | | | | | | | | |
| 3.4 | Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ. | 2 | - | - | - | 1 | 1 | - | 80.0 | 40.0 |
| 3.5 | Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ. | 5 | - | 2 | - | 1 | 1 | 1 | 54.0 | 52.0 |
| 3.6 | Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | 6 | - | 2 | 1 | - | 3 | - | 76.7 | 56.7 |
| **Нийт** | | **27** | **-** | **6** | **4** | **5** | **10** | **2** | **66.3** | **50.7** |

*(Эх сурвалж: "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Тус бодлогын хүрээнд дэвшүүлсэн 6 зорилтын 27 арга хэмжээнээс 10 арга хэмжээ "тодорхой үр дүнд хүрсэн'', 15 арга хэмжээ "эрчимжүүлэх шаардлагатай", 2 арга хэмжээ "үр дүнгүй" үнэлэгдсэн байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

"Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ" арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн нь дотоодод ямар хэмжээгээр үйлдвэрлэдэг болсон, улмаар орон сууцны өртөг буурсан эсэх талаар тайлагнаагүй, хэрэгжилт хангагдаагүй шалтгааны талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын тайланд тусгагдаагүй байна.

"Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ" арга хэмжээний хувьд 2023 онд хийгдсэн ажлын талаар тайлагнасан боловч 2024 онд хийгдсэн ажлын талаар тайлагнаагүй байна.

"Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна"- Хэрэгжилтийн үр дүн тодорхой бус тайлагнасан байна.

## 2.4.Эдийн засаг

Эдийн засаг бодлогын хүрээнд 6 зорилт, 35 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дундджаар 44.0 хувь буюу "эрчимжүүлэх шаардлагатай" байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг нь 72.6 хувь гэж үнэлснээс 28.6 нэгж хувиар үнэлгээ буурсан.

Үнэлгээ буурахад 19 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай, 6 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа ба хэрэгжилтийг дутуу тайлагнасан, үнэлгээний ангилал аргачлалын алдаа, зорилтын үр дүн хараахан гараагүй зэрэг нөлөөлсөн.

Хүснэгт 6. Эдийн засгийн бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| **Д/д** | **Зорилт** | **Арга хэмжээ** | **Хэрэгжилтийн хувь** | | | | | | **ЗГХХГ үнэлгээ, хувь** | **УИХТГ үнэлгээ, хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **100** | **90** | **70** | **50** | **30** | **0** | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ. | 7 | 0 | 0 | 0 | 0 | 4 | 3 | 78.6 | 17.1 |
| 4.2 | Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 16 | 1 | 1 | 2 | 5 | 4 | 3 | 65.0 | 43.8 |
| 4.3 | Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ. | 5 | 1 | 0 | 1 | 0 | 3 | 0 | 74.0 | 52.0 |
| 4.4 | Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлнэ. | 4 | 1 | 1 | 0 | 1 | 1 | 0 | 82.5 | 67.5 |
| 4.5 | Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ. | 2 | 0 | 0 | 1 | 0 | 1 | 0 | 80.0 | 50.0 |
| 4.6 | Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ. | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 90.0 | 90.0 |
| **Нийт** | | **35** | **3** | **3** | **4** | **6** | **13** | **6** | **72.6** | **44.0** |

*(Эх сурвалж: "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Эдийн засаг бодлогын хүрээнд дэвшүүлсэн 6 зорилтын 35 арга хэмжээнээс 3 арга хэмжээ "үр дүнтэй", 7 арга хэмжээ "тодорхой үр дүнд хүрсэн", 19 арга хэмжээ "эрчимжүүлэх шаардлагатай", 6 арга хэмжээ "үр дүнгүй" үнэлэгдсэн байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

"Эрчимжүүлэх шаардлагатай" болон "Үр дүнгүй" арга хэмжээний хэрэгжилт дараах хүчин зүйлээс шалтгаалсан байна. Үүнд:

- Зорилтын үр дүнг тайланд тусгаагүй, биелэлтийг бүрэн тайлагнаагүй;
  /4.5.1, 4.1.4, 4.1.5, 4.2.1, 4.2.2, 4.2.3, 4.3.3, 4.2.13, 4.2.15, 4.3.5./
- Аргачлалын дагуу үнэлээгүй;
  /4.1.6, 4.2.6, 4.2.12./
- Зорилтын үр дүн гарч эхлээгүй.
  /4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.7, 4.3.2, 4.4.1./

Үнэлгээ буурсан шалтгаан нь тус бодлогын 35 арга хэмжээнээс 25 арга хэмжээ буюу 74.1 хувь нь хэрэгжилтийг **“**эрчимжүүлэх шаардлагатай**”** болон **“**хэрэгжилт хангалтгүй**”** байгаа нь нөлөөлсөн.Тухайлбал:

- **4.1.3**.“Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх” арга хэмжээг “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолоор баталсан. Тус тогтоолын хүрээнд экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох ажлуудыг амжилттай гүйцэтгэж, хилийн боомтуудын үйл ажиллагаа идэвхжиж, экспорт нэмэгдсэнээр гадаад валютын улсын нөөц 2024 оны 11 сарын байдлаар 4,960.2 сая ам.долларт хүрч, оны эхнээс 38.8 сая ам.доллар буюу 0.8 хувиар өсөж, тогтвортой хадгалагдсан. Энэ нь манай орны валютын төлбөртэй импортын хэрэгцээний 5.1 сарын хэрэгцээг хангах түвшинд буюу олон улсад түгээмэл ашиглагддаг нөөцийн хүрэлцээт байдлын 3 сарын импортын хэрэгцээний үзүүлэлтээс өндөр байна. Монгол Улсын Засгийн газрын гадаад бондын төлбөр 2022-2024 онд нийт 2.4 тэрбум ам.доллартой тэнцэж байсан бөгөөд үүнийг төсвөөс төлж барагдуулсан тохиолдолд Гадаад валютын албан нөөц дээрх хэмжээгээр буурч төлбөрийн тэнцэлд дарамт учруулахаар байсныг Сенчири-1, 2, 3 бондуудыг олон улсын зах зээлд арилжаалснаар 2.0 тэрбум ам.доллартой тэнцэх гадаад валютыг хадгалж, төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулсан” гэж тайлагнаж 100 хувиар үнэлсэн байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж эхлэх хугацаа буюу 2021 оны 4 дүгээр сард ГВАН 4,891.6[3] сая ам.доллар байсан бол 2025 оны 01 дүгээр сард 4,884.28 сая ам.долларт**о**й тэнцэж байна. Бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн оноос ГВАН нэмэгдээгүй бөгөөд 2021 оны ДНБ=15,286.4 сая ам.долларт**о**й харьцуулахад 4,891.6[4] сая ам.доллар нь 32 хувьтай тэнцэж байсан бол 2024 оны ДНБ=23,584.9 сая ам.долларт**о**й харьцуулахад 4,884.28[5] сая ам.доллар нь 20.7 хувь болж буурсан. Иймд хэрэгжилт **“**Үр дүнгүй” гэж үзэж 0 хувиар үнэлсэн .

- **4.1.5**.“Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлэх” арга хэмжээг Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлэх зорилгоор Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 244 дүгээр тогтоолоор "Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай", Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 18 дугаар тогтоолыг болон импортоор оруулж байгаа 92 октантай автобензиний гаалийн албан татварын хэмжээг 0 хувиар тогтоосон "Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 35 дугаар тогтоолыг Засгийн газрын 2023 оны 12 сарын 20-ны өдрийн 455 дугаар тогтоолыг 2025 он хүртэл тус тус сунгасан” гэж тайлагнаж 50.0 хувиар үнэлсэн байна. Хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд бизнесийн таатай орчин хэрхэн бүрдсэн, иргэдийн худалдан авах чадвар хэдэн хувиар нэмэгдсэн зэрэг үр дүнгийн талаар тодорхойгүй байх тул бэлтэл ажил эхэлсэн гэж үзэж 0 хувиар үнэлсэн.

### 2.5.Засаглал

Засаглал бодлогын хүрээнд 6 зорилт, 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 49.6 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг 55.2 хувь гэж үнэлснээс 5.6 нэгж хувиар үнэлгээ буурсан.

---

[3] https://www.mongolbank.mn/mn/international-reserves
[4] 2021 оны ГВАН
[5] 2025 оны 01 дүгээр сарын байдлаарх ГВАН

Үнэлгээ буурахад үр дүнг тайлагнаагүй, бэлтгэл шатанд байгаа ажлыг тодорхой үр дүн гарсан мэт тайлагнасан, зорилтот түвшинд бүрэн хүрээгүй, гүйцэтгэл дутуу зэрэгтэй холбоотой арга хэмжээг аргачлалын[6] дагуу бууруулж үнэлсэн нь нөлөөлсөн.

**Хүснэгт 7. Засаглал бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | ЗГХХГ үнэлгээ, хувь | УИХТГ үнэлгээ, хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | |
| 5.1 | Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлнэ. | 4 | - | - | 3 | - | 1 | - | 60.0 | 60.0 |
| 5.2 | Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгоно. | 3 | - | 1 | - | 1 | - | 1 | 80 | 46.7 |
| 5.3 | Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ. | 4 | - | 1 | 2 | 1 | - | - | 70.0 | 70.0 |
| 5.4 | Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ. | 7 | - | - | 1 | 2 | 4 | - | 44.3 | 41.4 |
| 5.5 | Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлнэ. | 4 | - | - | - | 2 | - | 2 | 30.0 | 25.0 |
| 5.6 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 3 | - | 1 | - | 2 | - | - | 63.3 | 63.3 |
| **Нийт** | | **25** | **-** | **3** | **6** | **8** | **5** | **3** | **55.2** | **49.6** |

[6] Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлал

*(Эх сурвалж: “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Засаглал бодлогын хүрээнд дэвшүүлсэн 6 зорилтын 25 арга хэмжээнээс 9 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 13 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 3 арга хэмжээ “үр дүнгүй” хэрэгжсэн байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:** Засаглалын бодлогын хүрээнд “үр дүнгүй” болон “эрчимжүүлэх шаардлагатай” 15 арга хэмжээ буюу нийт арга хэмжээний 60 хувийг эзэлж байгаа нь бодлогын хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна. Түүнчлэн:

5.5.2.“Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшүүлэх” арга хэмжээ хэрэгжээгүй;

5.5.4.“Шүүх засаглалыг улс төр, бизнесийн бүлгийн ашиг сонирхлоос ангид, хараат бус байлгаж, шүүхийн үйл ажиллагаанд шударга ёсыг тогтоож, иргэдийн итгэлийг сэргээж ажиллах” талаар хэрэгжилт тайлагнаагүй;

5.2.2.“Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн оновчтой зохицуулалт хийгдэх” арга хэмжээний хувьд БНСУ-ын Засаг захиргаа, дотоод хэргийн яамнаас гаргасан чиг үүргийн талаар “Төрийн урлахуй” сэдвээр материал боловсруулсан, мөн “Байгууллагыг шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнтэй оношлох гарын авлага”-ыг монгол хэл дээр бэлтгэн гаргасан” гэж тайлагнасан нь тус арга хэмжээ зорилт, хүрэх түвшнийг хангасан үр дүн гарсан гэж үзэх боломжгүй, тус арга хэмжээний гүйцэтгэл “0” хувьтай үр дүнгүй байна.

## 2.6.Ногоон хөгжил

Ногоон хөгжил бодлогын хүрээнд 4 зорилт, 18 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар **56.7** хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг нь 63.9 хувь гэж үнэлсэнээс 7.2 нэгж хувиар үнэлгээ нь буурсан.

Үнэлгээ буурахад зорилтот түвшинд хүрээгүй, үр дүн тодорхойгүй, тайлагналт хангалтгүй, гүйцэтгэл, үр дүн бүрэн хангагдаагүй арга хэмжээг аргачлалын[7] дагуу бууруулж үнэлсэн нь нөлөөлсөн.

Хүснэгт 8.Ногоон хөгжил бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | ЗГХХГ үнэлгээ, хувь | УИХТГ үнэлгээ, хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | |
| 6.1 | Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ. | 2 | - | - | 1 | - | 1 | - | 60.0 | 50.0 |
| 6.2 | Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон | 5 | - | 3 | - | 2 | - | - | 76.0 | 74.0 |

[7] Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлал

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдлыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно. | | | | | | | | | |
| 6.3 | Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ. | 4 | - | 1 | 1 | 1 | 1 | - | 70.0 | 60.0 |
| 6.4 | Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлнэ. | 7 | - | 1 | - | 2 | 4 | - | 52.9 | 44.3 |
| **Нийт** | | **18** | **-** | **5** | **2** | **5** | **6** | **-** | **63.9** | **56.7** |

*(Эх сурвалж: “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Ногоон хөгжил бодлогын хүрээнд дэвшүүлсэн 4 зорилтын 18 арга хэмжээнээс 7 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 11 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

Ногоон хөгжил бодлогын хүрээнд хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшнийг бүрэн хангаагүй, тайлагналт хангалтгүй буюу хийгдсэн ажлыг дутуу тайлагнах, үр дүн тодорхойгүй, зорилт, арга хэмжээний агуулгаас зөрүүтэй ажлыг тайлагнах байдал нийтлэг байна. Тухайлбал:

6.4.5.“Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг нэмэгдүүлж, 20 хувьд хүргэнэ”**;**

6.3.3.“Нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангасан байна.”; гэсэн арга хэмжээний хэрэгжилтийн тайланд Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь нэмэгдсэн эсэх, шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хүн амын хичнээн хувийг хангаж байгаа талаарх мэдээлэл, тайлагналт байхгүй, тодорхойгүй байгаа нь хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.

## 2.7.Амар тайван, аюулгүй нийгэм

Тус бодлогын хүрээнд 5 зорилт, 23 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 60.4 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг нь 81.7 хувь гэж үнэлснээс 21.3 нэгж хувиар үнэлгээ буурсан.

Үнэлгээ буурахад 20 арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тайланд тусгаагүй, дутуу тайлагнасан, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн, гүйцэтгэл тодорхой хэмжээнд гарч эхэлж буй ажлыг үр дүн гарсан мэт тайлагнаж, үнэлсэн нь нөлөөлсөн.

Хүснэгт 9. Амар тайван, аюулгүй нийгэм бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | ЗГХХГ үнэлгээ, хувь | УИХТГ үнэлгээ, хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | | |
| 7.1 | Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ. | 4 | - | - | 1 | 3 | - | - | 70.0 | 55.0 |
| 7.2 | Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. | 4 | - | 1 | 3 | - | - | - | 87.5 | 75.0 |
| 7.3 | Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | 6 | - | 1 | 3 | 1 | 1 | - | 76.7 | 63.3 |
| 7.4 | Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ. | 7 | - | - | 3 | 3 | 1 | - | 88.6 | 55.7 |
| 7.5 | Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ. | 2 | - | - | - | 2 | - | - | 85.0 | 50.0 |
| **НИЙТ** | | **23** | **-** | **2** | **10** | **9** | **2** | **-** | **81.7** | **60.4** |

*(Эх сурвалж: “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Амар тайван, аюулгүй нийгэм бодлогын хүрээнд дэвшүүлсэн 5 зорилтын 23 арга хэмжээнээс 12 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 11 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай” байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

Тус бодлогын хүрээнд 7 арга хэмжээний үр дүнг тайланд тусгаагүй, 7 арга хэмжээний гүйцэтгэл тодорхой хэмжээгээр гарч эхэлж байна.

## 2.8.Бүс, орон нутгийн хөгжил

Тус бодлогын хүрээнд 3 зорилт, 29 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт дунджаар 61.7 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас энэ бодлогын хэрэгжилтийг 61.7 хувь гэж үнэлсэн байна.

Хүснэгт 10. Бүс, орон нутгийн хөгжил бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| **Д/д** | **Зорилт** | **Арга хэмжээ** | **Хэрэгжилтийн хувь** | | | | | | **ЗГХХГ үнэлгээ, хувь** | **УИХТГ үнэлгээ, хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **100** | **90** | **70** | **50** | **30** | **0** | | |
| 8.1 | Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно. | 11 | 1 | 2 | 4 | 3 | 1 | - | 67.3 | 67.3 |
| 8.2 | Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 3 | - | - | 2 | - | - | 1 | 46.7 | 46.7 |
| 8.3 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ. | 15 | - | 1 | 8 | 4 | 2 | - | 60.7 | 60.7 |
| **НИЙТ** | | **29** | **1** | **3** | **14** | **7** | **3** | **1** | **61.7** | **61.7** |
| | | | | | | | | | | |

*(Эх сурвалж: “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Бүс, орон нутгийн хөгжил бодлогын хүрээнд дэвшүүлсэн 3 зорилтын 29 арга хэмжээнээс 1 арга хэмжээ “үр дүнтэй’’, 17 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн’’, 10 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 1 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдсэн байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ’’ арга хэмжээг “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан боловч ТЭЗҮ, үзэл баримтлалын асуудал Улсын Их Хурлын Байнгын хорооны хурлаар орж дэмжигдээгүй тул Азийн хөгжлийн банкнаас тус төслийг цаашид хэрэгжүүлэхгүй гэсэн шийдвэрийг гаргасантай холбоотойгоор тус төсөл хэрэгжээгүй байна.

## 2.9.Улаанбаатар ба дагуул хот

Улаанбаатар ба дагуул хот бодлогын хүрээнд 5 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан ба хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд хэрэгжилт дунджаар 52.9 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай’’ байна.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас энэ бодлогын хэрэгжилтийг 57.1 хувь гэж үнэлснээс 4.2 нэгж хувиар буурсан.

Үнэлгээ буурахад 18 арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг тайланд тусгаагүй, хэрэгжилтийг дутуу тайлагнасан, аргачлалын дагуу үнэлээгүй, шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй, зохион байгуулалт удаашралтай, арга хэмжээний агуулгаас өөр арга

хэмжээ тайлагнасан, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн, гүйцэтгэл нь тодорхой хэмжээнд гарч эхэлж буй ажлыг үр дүн гарсан мэт тайлагнаж, үнэлсэн нь нөлөөлсөн.

Хүснэгт 11. Улаанбаатар ба дагуул хот бодлогын хэрэгжилт (хамаарах зорилт хэрэгжилтийн хувиар)

| **Д/д** | **Зорилт** | **Арга хэмжээ** | **Хэрэгжилтийн хувь** | | | | | | **ЗГХХГ үнэлгээ, хувь** | **УИХТГ үнэлгээ, хувь** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **100** | **90** | **70** | **50** | **30** | **0** | | |
| 9.1 | Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ | 3 | - | 2 | - | - | 1 | - | 70.0 | 70.0 |
| 9.2 | Ирэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангаж, нөхөн сэргээх, харицлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно. | 4 | - | - | 1 | 1 | 1 | 1 | 60.0 | 37.5 |
| 9.3 | Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ. | 5 | - | 1 | - | 2 | 2 | - | 50.0 | 50.0 |
| 9.4 | Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ. | 3 | 1 | - | 1 | 1 | - | - | 73.3 | 73.3 |
| 9.5 | Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ. | 6 | - | 1 | - | 2 | 3 | - | 46.7 | 46.7 |
| | | **21** | **1** | **4** | **2** | **6** | **7** | **1** | **57.1** | **52.9** |
| | | | | | | | | | | |

*(Эх сурвалж: "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан)*

Улаанбаатар ба дагуул хот бодлогын хүрээнд дэвшүүлсэн 5 зорилтын 21 арга хэмжээнээс 1 арга хэмжээ "үр дүнтэй", 6 арга хэмжээ "тодорхой үр дүнд хүрсэн'', 13 арга хэмжээ "эрчимжүүлэх шаардлагатай", 1 арга хэмжээ "үр дүнгүй" үнэлэгдсэн байна.

**Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний шалтгаан нөхцөл:**

"Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна." гэсэн арга хэмжээний хувьд Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр үзэхэд хүхэрлэг хий, PM10, PM2.5 утга сүүлийн жилүүдэд өсөлттэй буюу агаарын бохирдол буураагүй байгаа бөгөөд хэрэгжилт хангагдаагүй шалтгааны талаар тайлагнаагүй байна.

## ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг баталсан ба үүнд 95 шалгуур үзүүлэлт, түүний суурь түвшнийг 2018, 2019, 2020 оны байдлаар, хүрэх түвшнийг 2025 оноор тодорхойлж баталсан. Түүнчлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх 82 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг жилд 1 удаа, 5 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл

цуглуулах давтамжийг 5 жилд 1 удаа, 4 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг 2 жилд 1 удаа, 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг улирал бүр байхаар тус тус тодорхойлж баталсан байх ба 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг тодорхойлоогүй байна.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д тусгагдсан 9 зорилго, 47 зорилтыг хангахад чиглэгдсэн 243 арга хэмжээг хэмжих 95 шалгуур үзүүлэлтээс хүрсэн түвшнийг тодорхойлсон 67 шалгуур үзүүлэлтийн 30 нь буюу 44.8 хувь нь тухайн жилийн зорилтдоо хүрсэн, 37 нь буюу 55.2 хувь нь зорилтот түвшиндээ хүрээгүй, 18 шалгуур үзүүлэлтийн тайлагнах хугацаа болоогүй, 7 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг тодорхойлох боломжгүй, 2 үзүүлэлтийн хүрсэн түвшний талаарх тайлан мэдээлэл нэгтгэгдээгүй байна.

## ГУРАВ.ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг шинжлэх зорилготой үр дүнгийн шинжилгээ хийлээ.

Үр дүнгийн шинжилгээ хийхдээ дараах эх сурвалжийг нотолгоо болгон авсан. Үүнд:

1.Үндэсний статистикийн хорооны дүн мэдээ; (Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2025 оны тайлан)

2.Олон улсын байгууллага, судалгааны институтээс гаргадаг өрсөлдөх чадварын индекс; Тухайлбал, цахим засаглалын индекс (НҮБ), авлигын төсөөллийн индекс (Транспарэнси Интернэшнл), байгаль орчны гүйцэтгэлийн индекс (Йелийн их сургууль), олон улсын тээвэр, дэд бүтцийн чанарын индекс (Дэлхийн банк) дэлхийн энх тайвны индекс (Хэритэж сан), дэлхийн инновацын индекс (Дэлхийн эдийн засгийн форум) зэрэг индексийг тооцох юм.

**Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:**

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 3-5 настнуудын хамрагдалт 92.9 хувьтай, 5 настнуудын хамрагдалт 94.1 хувьтай байна. Ерөнхий боловсролын сургуулийн хамрагдалт 96 хувьтай байна.

Зураг 3.







- Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагаас гаргасан олон улсын сурлагын амжилтын үнэлгээ (PISA.,OECD.,2022 анг.)-гээр математикийн хичээлийн амжилт 49 хувь, олон улсын дундаж 69 хувьтай байна. Уншиж ойлгох чадвар чадварын амжилт 36 хувьтай, ЭЗХХАБ-ын орнуудын дундаж 74 хувьтай байна. Шинжлэх ухааны мэдлэг 50 хувь, олон улсын дундаж 76 хувьтай байна.[8]

[8] PISA 2022 Results Factsheets Mongolia

- 2024 оны байдлаар улсын хэмжээнд 349 шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар шинээр патент авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28 буюу 7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Дэлхийн инновацын индекс (GII анг.)-ээр дэлхийн 133 улсаас 67 дугаарт эрэмбэлэгдэж байна. Үүнээс зах зээлийн төвөгтэй байдал 106 дугаарт, мэдээлэл технологийн гарц 86 дугаарт тус тус эрэмбэлэгджээ.

**Амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын хүрээнд:**

- Хөдөлмөр эрхлэлтийг эрчимжүүлэх зорилт дэвшүүлсэн боловч сүүлийн 3 жил хөдөлмөр эрхлэлт дорвитой нэмэгдээгүй, харин нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өссөн байна. Хөдөлмөр эрхлэлт 2024 онд 2023 оны мөн үеэс 1.03 хувиар нэмэгдсэн байна.
- Төрөлт 2022 онтой харьцуулахад 1.01 хувиар буурсан.
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргадаг Хүний хөгжлийн индекс (HDI анг.)-ээр[9] 0.741 оноотой буюу “өндөр” үнэлгээтэй байна. 2022 оны байдлаар дэлхийн дундаж үнэлгээ 0.739 оноо байна.

Зураг 4.




**Эдийн засгийн бодлогын хүрээнд:**

- 2024 онд 19196 орон сууц ашиглалтад орж, 8889 иргэн ипотекийн зээл авч, 2492 иргэн түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамрагдсан байна. Нийслэлийн гэр хороололд 231.479 сууц инженерийн дэд бүтцэд холбогдоогүй байна.
- Хүн амын 43 хувь нь шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар, 52 хувь нь шаардлага хангасан усны эх үүсвэрээр хангагдсан байна.
- Зээлийн хүү 2024 оны байдлаар 16.89 буюу 2023 оны мөн үеэс 0.6 хувиар өссөн байна.
- Эдийн засгийн эрх чөлөөний индекс[10] (IEF анг.)-ээр 60.6 оноотой байна. Үүнээс төрийн байгууллагын уялдаа холбоо 34, өмчлөх эрх 48.8, санхүүгийн эрх чөлөө 50, хөрөнгө оруулалтын эрх чөлөө 50 буюу эдгээр үзүүлэлт бага үнэлгээтэй байгаа нь дундаж оноог буурахад нөлөөлж байна.
- Олон улсын тээврийн дэд бүтцийн чанар, чадавхын индекс[11] (LPI )-ээр дэлхийн 139 улсаас 97 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Үүнд: тээврийн үнэлгээ 2.1, ачаа тээврийн мөшгөлт 2.1, дэд бүтцийн үнэлгээ 2.1, гаалийн үнэлгээ 2.2 оноотой буюу бага үзүүлэлттэй байна.

Зураг 5.

[9] hdr.undp.org/data-center/country-insights
[10] Heritage.org/index/pages/all-country-scores
[11] Lpi.worldbank.org/international/global







- Замын чанарын индекс[12] (QRI )-ийн үзүүлэлт 6.5 байхаас 3.5 оноотой байна.
- Нийт экспортын 91 хувь, нийт импортын 32.8 хувь нь БНХАУ-д ногдож байна.
- 2023 оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспорт 3.9 хувиар өссөн байна. Гэвч БНХАУ-ын зах зээл дээр нүүрсний үнэ 2023 оны 1 дүгээр сараас эхлэн тасралтгүй буурч, 2024 оны 12 дугаар сарын байдлаар тн тутам 258 ам.доллар[13] болж буурсан байна.
- Нефть, шатахууны импорт нийт импортын хувийг эзэлж дизель түлш 37.1 хувиар, автобензиний импорт 7.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 6.







**Засаглал бодлогын хүрээнд:**

- Авлигын төсөөллийн индекс[14] (Corruption perception index)-ээр сүүлийн 3 жилд 33 оноотой явж, 2024 онд дэлхийн 180 улсаас 114 дүгээрт эрэмбэлэгдсэн байна.
- Дэлхийн банкнаас гаргадаг 2023 оны Засаглалын индекс[15] (Governance Index)-ээр Засгийн газрын үр нөлөө -0.5, авлигын хяналт -0.6 оноотой буюу хамгийн бага үзүүлэлттэй байгаа бол улс төрийн тогвортой байдал 0.6, иргэдийн дуу хоолойгоо илэрхийлэх эрч чөлөө 0.3 оноотой буюу хамгийн өндөр байна.

Зураг 7.







12 worldpopulationreview.com/country-rankings/road-quality-by-country
13 Tradingeconomics.com/commodity/coal
14 Transparency.org/en/countries/mongolia
15 Worldbank.org/en/publication/worldwide-governance-indicators

- Цахим засаглалын индекс[16] (E-government index анг.)-ээр дэлхийн 193 улсаас 0.8457 оноогоор 46 дугаар байранд, цахим оролцооны индексээр 37 дугаар байранд тус тус эрэмбэлэгдсэн байна. Цахим засаглалаар Зүүн хойд азийн бүс нутагт тэргүүлэгч БНСУ 0.9679 оноотой, Ази номхон далайд тэргүүлэгч Сингапур улс 0.9691 оноотой байна.
- Цахим аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2024 онд **2023** оны мөн үетэй харьцуулахад 68 буюу 17.5 хувиар өссөн байна.

Зураг 8.







- Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага ФАТФ (FATF) стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас 2020 онд гарсан.




2023 оны байдлаар Базел индекс (Basel index анг.)-ээр эрсдлийн үзүүлэлт буурч нийт 152 улсаас 83 дугаарт жагссан байна.

**Ногоон хөгжил бодлогын хүрээнд:**

Байгаль орчны гүйцэтгэлийн индекс (EPI)-ээр дэлхийн 180 улсаас 177 дугаарт эрэмбэлэгдэж байна. Агаарын чанар 160, PM 2.5 ялгарлаар 171, хог хаягдлын менежментээр 176 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

**Амар тайван, аюулгүй нийгэм бодлогын хүрээнд:**

- Монгол Улсаас НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд 3 жилд дундажаар 889.5 энхийг сахиулагч илгээж, 62-71 байрт эрэмбэлэгдсэн нь хүн амын тоотой харьцуулахад оролцоо өндөр гэж үнэлэгдсэн.
- “Оюутан цэрэг” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр сүүлийн 2 жилд 1200 иргэн уг хөтөлбөрт хамрагдсан байна.

Зураг 9.




Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2024 онд гэмт хэрэгт 1675 хүүхэд холбогдож шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 81 буюу 5.1 хувиар өссөн байна.

[16] Publicadministration.un.org/egovkb/en-us/Data-Country-information

- Гэмт хэрэгт холбогдсон, гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо тасралтгүй өсч байна. Сургууль орчимд үйлдэгдсэн гэмт хэргийн тоогоор ерөнхий боловсролын сургууль орчин хамгийн өндөр байна.

Зураг 10.







## ДӨРӨВ.“МОНГОЛ УЛСЫГ 20121-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-Д ТУСГАСАН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ХҮРЭХ ҮР ДҮН НЬ УРТ, ДУНД ХУГАЦААНЫ БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ХҮРЭХ ҮР ДҮНГ ХАНГАСАН ЭСЭХ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5 дахь хэсэгт заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг дараах шалтгааны улмаас төсөл, арга хэмжээ тус бүрийн хувиар харьцуулан тооцох боломжгүй байна. Үүнд:

1.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн бодлогын зорилго, зорилт, арга хэмжээний хүрэх үр дүн, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг он тус бүрээр төлөвлөж, тодорхойлоогүй байна.

2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн бодлогын баримт бичигт агуулгын хувьд ойролцоо төсөл, арга хэмжээ тусгагдсан байх боловч яг ижил арга хэмжээ тусгагдаагүй байгаа тул биелэлтийг харьцуулах боломжгүй байна.

3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт 9 зорилгын хүрээнд 47 зорилт, 965 арга хэмжээний шалгуур үзүүлэлт, түүний суурь түвшин, зорилтот түвшнийг батлаагүй, 73 шалгуур үзүүлэлтийг баталсан ба шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг 2025 он, 2030 он, 2050 оноор тус тус тодорхойлсон. 2024 оны 10 дугаар сарын байдлаар 73 шалгуур үзүүлэлтээс 13 шалгуур үзүүлэлтийн тайлан гарсан бөгөөд 60 шалгуур үзүүлэлтийн тайлан гарах хугацаа болоогүй байна. 2025 оны зорилтод түвшнийг хангасан 8 шалгуур үзүүлэлт байх тул түүний хэдэн хувьд хүрснийг тооцох боломжгүй байна.

4.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдаагүй, арга хэмжээ тус бүрийн суурь түвшин, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг батлаагүй байгаа тул түүний хэдэн хувьд хүрснийг арга хэмжээ бүрээр харьцуулан шинжлэх боломжгүй байна.

Иймд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн бодлогын баримт бичиг нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 620 зорилттой хэрхэн уялдаж байгааг шинжиллээ.

Хүснэгт 12. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Алсын хараа-2050”Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн агуулгын уялдаа (Хяналт шалгалтын тухай хууль 18.3.3)

| № | Бодлого | **МУХТЖҮЧ-нд тусгасан нийт арга хэмжээ** | **ЗГҮАХ-т агуулгын хувьд уялдаж байгаа арга хэмжээний тоо** | **Бодлогын баримт бичгүүдийн уялдаа /хувиар/** | **“Алсын хараа-2050” бодлогын баримт бичигтэй уялдсан арга хэмжээний тоо** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндэсний нэгдмэл үнэт зүйл | 16 | 1 | 6.3 | |
| 2 | Хүний хөгжил | 49 | 23 | 46.9 | |
| 3 | Амьдралын чанар ба дундаж давхарга | 27 | 13 | 48.1 | |
| 4 | Эдийн засаг | 35 | 20 | 57.1 | |
| 5 | Засаглал | 25 | 12 | 48.0 | 185 |
| 6 | Ногоон хөгжил | 18 | 9 | 50.0 | |
| 7 | Амар тайван, аюулгүй нийгэм | 23 | 13 | 56.5 | |
| 8 | Бүс, орон нутгийн хөгжил | 29 | 17 | 58.6 | |
| 9 | Улаанбаатар ба дагуул хот | 21 | 8 | 38.1 | |
| Нийт | | **243** | **116** | **45.5** | **76.1** хувь |

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан нийт 243 арга хэмжээнээс 116 арга хэмжээ буюу 45.5 хувь нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, 185 арга хэмжээ буюу 76.1 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт агуулгын хувьд тус тус тусгагдсан байна.

## ТАВ.“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ” НЬ ЗОРИЛТОТ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХАНГАСАН БОЛОН БҮРЭН ХЭРЭГЖСЭН ЭСЭХЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Зураг 11.




“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт 2022 онд 73.45 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн”, 2023 онд 75.3 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн”, 2024 онд 65.0 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Тус бодлогын баримт бичгийн 2022-2024 оны хэрэгжилт дунджаар **71.25** хувь буюу "тодорхой үр дүнд хүрсэн'' гэсэн үнэлгээний ангилалд хамаарч байна.

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд тусгасан 243 арга хэмжээний 6 нь буюу 2.5 хувь нь үр дүнтэй, 89 нь буюу 36.6 хувь нь "тодорхой үр дүнд хүрсэн", 127 нь буюу 52.2 хувь нь "эрчимжүүлэх шаардлагатай", 21 нь буюу 8.6 хувь нь "үр дүнгүй" үнэлэгдсэн байна.

"Үр дүнгүй'', **"**хэрэгжилт хангалтгүй**"** байгаа 21 арга хэмжээнд шинжилгээ хийхэд 6 нь буюу 28.5 хувь нь үйл ажиллагааны зохион байгуулалтаас, 6 нь буюу 28.5 хувь нь төлөвлөлт тайлагналттай холбоотой, 6 нь буюу 28.5 хувь нь шийдвэр гаргалт, зохион байгуулалттай холбоотой, 4.7 хувь нь хэрэгжүүлэгчдийн уялдаа холбооноос, 9.5 хувь нь арга аргачлалаас шалтгаалсан байна.

Хүснэгт 13. "Үр дүнгүй" арга хэмжээний тоо, хувь

| **Д/д** | **Бодлого** | **Төсөл, арга хэмжээний тоо** | **Хэрэгжилт хангагдаагүй төсөл, арга хэмжээ** | |
|---|---|---|---|---|
| | | | **Тоо** | **Хувь** |
| 1 | Үндэсний нэгдмэл үнэт зүйл | 16 | 5 | 2.0 |
| 2 | Хүний хөгжил | 49 | 3 | 3.9 |
| 3 | Амьдралын чанар ба дундаж давхарга | 27 | 2 | 0.8 |
| 4 | Эдийн засаг | 35 | 6 | 2.47 |
| 5 | Засаглал | 25 | 3 | 1.23 |
| 6 | Ногоон хөгжил | 18 | 0 | - |
| 7 | Амар тайван, аюулгүй нийгэм | 23 | 0 | - |
| 8 | Бүс, орон нутгийн хөгжил | 29 | 1 | 0.4 |
| 9 | Улаанбаатар ба дагуул хот | 21 | 1 | 0.4 |
| **Нийт** | | **243** | **21** | **11.2** |

Зураг 12 . Бүрэн хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийн бүтэц




"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд тусгасан бүрэн хэрэгжээгүй арга хэмжээний хувьд төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжүүлэгчдийн уялдаа холбоог сайжруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг зөв сонгож үнэлэх, шалгуур үзүүлэлт зорилтот түвшний дагуу гол үр дүнг тайлагнах шаардлагатай байна.

## ЗУРГАА.САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ:

"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 243 арга хэмжээнд хамаарах 99 арга хэмжээнд **8.531.8** тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд нийт санхүүжилтийн 6.8 хувийг улсын төсвөөр /68 арга хэмжээ/, 15.0 хувийг гадаадын зээл, тусламжаар /7 арга хэмжээ/, 0.2 хувийг Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгөөр /1 арга хэмжээ/, 0.2 хувийг орон нутгийн хөрөнгөөр /8 арга хэмжээ/, 1.7 хувийг

Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр /7 арга хэмжээ/, 76.1 хувийг бусад эх үүсвэрээр /8 арга хэмжээ/ санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 14. Арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/

| Д/д | Бодлого | Арга хэмжээ | Санхүүжсэн арга хэмжээ | Санхүүжилт /тэрбум төгрөг/ | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын төсөв | Гадаадын зээл, тусламж | Концесс, ТХХТ | Орон нутаг | Тусгай сан | Бусад |
| 1 | Үндэсний нэгдмэл үнэт зүйл | 16 | 11 | **8.6** | 8.6 | - | - | - | - | - |
| 2 | Хүний хөгжил | 49 | 21 | **284.1** | 123.3 | - | 20 | - | 91.2 | 49.4 |
| 3 | Амьдралын чанар ба дундаж давхарга | 27 | 8 | **889.2** | 28.9 | 860.3 | - | - | - | - |
| 4 | Эдийн засаг | 35 | 14 | **1,315.6** | 26.0 | 207.2 | - | - | 44.8 | 1,037.6 |
| 5 | Засаглал | 25 | 3 | **4.5** | 4.5 | - | - | - | - | - |
| 6 | Ногоон хөгжил | 18 | 13 | **31.5** | 30.2 | 0.2 | - | 0.7 | - | 0.2 |
| 7 | Амар тайван, аюулгүй нийгэм | 23 | 5 | **52.9** | 26 | - | - | - | 9.5 | 17.5 |
| 8 | Бүс, орон нутгийн хөгжил | 29 | 11 | **5.767.2** | 218.6 | 156.9 | - | - | - | 5.391.6 |
| 9 | Улаанбаатар ба дагуул хот | 21 | 13 | **178.2** | 113.9 | 52.3 | - | 11.9 | - | - |
| **Нийт** | | **243** | **99** | **8.531.8** | **580.0** | **1.277.1** | **20.0** | **12.6** | **145.5** | **6.496.3** |

*Эх сурвалж:Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтийн тайлан*

Нийт санхүүжилтийг бодлогоор нь авч үзвэл Бүс, орон нутгийн хөгжил бодлогын 11 арга хэмжээнд 5.767.2 тэрбум төгрөг /67.6 хувь/, Эдийн засгийн бодлогын 14 арга хэмжээнд 1,315.6 тэрбум төгрөг /15.4 хувь/, Амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын 8 арга хэмжээнд 889.2 тэрбум төгрөг /10.4 хувь/, Хүний хөгжил бодлогын 21 арга хэмжээнд 284.1 тэрбум төгрөг /3.3 хувь/, Улаанбаатар ба дагуул хот бодлогын 13 арга хэмжээнд 178.2 тэрбум төгрөг /2.1 хувь/, Амар тайван, аюулгүй нийгэм бодлогын 5 арга хэмжээнд 52.9 тэрбум төгрөг /0.6 хувь/, Ногоон хөгжил бодлогын 13 арга хэмжээнд 31.5 тэрбум төгрөг /0.4 хувь/, Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын 11 арга хэмжээнд 8.6 тэрбум төгрөг /0.1 хувь/, Засаглал бодлогын 3 арга хэмжээнд 4.5 тэрбум төгрөг /0.1 хувь/-ийг тус тус зарцуулжээ.

Хүснэгт 15.Хэрэгжээгүй буюу үр дүнгүй үнэлэгдсэн арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл /сая төгрөгөөр/

| Д/д | Бодлого | Арга хэмжээ | Зарцуулсан хөрөнгө | Эх үүсвэр | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндэсний нэгдмэл үнэт зүйл | Үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монгол үндэсний нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ. | 15.0 | Улсын төсөв | |
| 2 | | Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодорхойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ. | 1.165.2 | Улсын төсөв | |
| 3 | | Үндэсний соёл, урлаг, зан заншил, ахуй, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлж, өргөжүүлнэ. | 3.000.0 | Улсын төсөв | Бодлогын зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлээгүй. |
| 4 | Хүний хөгжил | Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ. | 1.366.3 | Улсын төсөв | Тайлагналт буруу |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Амьдралын чанар ба дундаж давхарга | Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгоно. | 860.345.7 | Гадаадын зээл, тусламж | Тухайн хэрэгжиж буй төслийн хүрээнд баригдаж буй барилга нь өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн эсэх нь тодорхойгүй, хэмжигдэхүйц бус байдлаар тайлагнасан. |
| | **Нийт** | | **865.892.2** | | |

*Эх сурвалж: Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтийн тайлан*

## ДОЛОО.ДҮГНЭЛТ

1.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн 2024 оны хэрэгжилт 52.6 хувь байна. Энэ нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хэрэгжилтийг нь 66.7 хувь гэж үнэлснээс 12.4 нэгж хувиар үнэлгээ буурсан . Үнэлгээ буурсан нь үр дүнг бүрэн тайлагнаагүй, аргачлалын дагуу үнэлээгүй, зарим санхүүжилт батлагдаагүй, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувь, шалгуур үзүүлэлтийг хангаагүй, бэлтгэл ажил дуусаагүй, тодорхой үр дүн гарч эхлээгүй, авсан арга хэмжээ, үр дүнг тайлагнаагүй, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, гүйцэтгэл дутуу зэрэгтэй холбоотой үр дүнг дутуу тайлагнасан, аргачлалын дагуу үнэлээгүй зэргээс шалтгаалж байна.

2.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн 243 арга хэмжээний 2.5 хувь нь буюу 6 арга хэмжээ үр дүнтэй, 36.6 хувь нь буюу 89 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 52.2 хувь нь буюу 127 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 8.6 хувь нь буюу 21 арга хэмжээ “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

3.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-ийн 9 зорилго, 47 зорилтыг хангахад чиглэгдсэн 243 арга хэмжээг хэмжих 95 шалгуур үзүүлэлтийн 30 нь буюу 44.8 хувь нь зорилтот түвшинд хүрсэн, 37 нь буюу 55.2 хувь нь зорилтот түвшинд хүрээгүй, 18 шалгуур үзүүлэлтийг тайлагнах хугацаа болоогүй, 7 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг тодорхойлох боломжгүй, 2 үзүүлэлтийн хүрсэн түвшний талаарх тайлан нэгтгэгдээгүй байна.

4.“Үр дүнгүй’’, хэрэгжилт хангалтгүй байгаа 21 арга хэмжээнд шинжилгээ хийхэд 6 нь буюу 28.5 хувь нь үйл ажиллагааны зохион байгуулалтаас, 6 нь буюу 28.5 хувь нь төлөвлөлт тайлагналттай холбоотой, 6 нь буюу 28.5 хувь нь шийдвэр гаргалт, зохион байгуулалттай холбоотой, 4.7 хувь нь хэрэгжүүлэгчдийн уялдаа холбооноос, 9.5 хувь нь арга аргачлалаас шалтгаалсан байна.

5.Тус бодлогын 9 зорилгын хэрэгжилтэд үр дүнгийн шинжилгээ хийсэн ба цаашид “үр дүнтэй”, “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн бодлогын зорилт, арга хэмжээг санхүүжилт, төсвийн шинжилгээтэй уялдуулан шинжлэн дүгнэж байх шаардлагатай байна.

6. “Алсын хараа-2050’’ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын зорилго, зорилт, арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшин, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг он тус бүрээр оновчтой төлөвлөж, тодорхойлоогүй, урт хугацааны бодлогын баримт бичгийн хүрэх түвшнийг 2025 он, 2030 он, 2050 оноор тус тус тодорхойлсон, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлаагүй байх тул Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтад заасны дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан зорилго,

зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 6.2, 6.5-заасан чиглэлд заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг арга хэмжээ тус бүрийн хувиар харьцуулан тооцох боломжгүй байна.

7. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл’’-д тусгасан нийт 243 арга хэмжээнээс 116 арга хэмжээ буюу 45.5 хувь нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, 185 арга хэмжээ буюу 76.1 хувь нь “Алсын хараа-2050’’ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт агуулгын хувьд тус тус тусгагдсан байна.

8.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн 3 жилийн динамик өөрчлөлтийг авч үзвэл 2022 онд 73.45 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн”, 2023 онд 75.3 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн”, 2024 онд 65.0 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн байна.

9.“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зарим арга хэмжээний суурь түвшин, зорилтот түвшнийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгийн хэмжээг урьдчилан тооцоолоогүйгээс хэрэгжилт хангагдахгүй нөхцөл үүсч байх тул зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө он тус бүрээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг батлах, санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгахдаа оновчтой, бодитой төлөвлөж, санхүүжүүлэх шаардлагатай байна.

## НАЙМ.ЗӨВЛӨМЖ

1.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг Монгол Улсын урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан он тус бүрээр шалгуур үзүүлэлт, хүрэх үр түвшингийн үзүүлэлттэйгээр баталж, хэрэгжүүлэх;

2.Бодлогын баримт бичгийн биелэлтийн тайланг ирүүлэхдээ бодлогын үр дүн, үр нөлөө, шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг тайлагнаж, хэрэгжилт хангалтгүй төсөл, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тайлагнаж, үнэлж ирүүлдэг байх;

3.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтад заасны дагуу үндсэн чиглэлд тусгасан зорилго зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.5 дахь хэсэгт заасан урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт тус бүрээр хуульд заасан шаардлагын дагуу иж бүрэн тайлагнах;

4.Арга хэмжээний хүрэх үр дүнг төлөвлөхдөө хэмжигдэхүйц утгаар илэрхийлэх, ажлын гүйцэтгэл, гол үр дүнг төлөвлөх, тайлагнах;

5.Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлж, төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтыг цогцоор хийхэд анхаарах;

6.Дунд хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжүүлэгч байгууллагууд, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Улсын Их Хурлын Тамгын газраас санал авч, төлөвлөлтийг гүйцэтгэх.

---oOo---

Хавсралт 1

## “МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ’’-ИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГҮЙ (0-29) ҮНЭЛЭГДСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилт, арга хэмжээ | ЗГХХГ-ын үнэлгээ, хувь | УИХТГ-ын үнэлгээ, хувь |
|---|---|---|---|
| | **Нэг.Үндэсний нэгдмэл үнэт зүйл** | | |
| 1 | 1.2.3.үндэсний сор бүтээл, брэнд, үндэсний шинэлэг бүтээл зэргийг монгол үндэсний нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээнэ. | 0 | 0 |
| 2 | 1.2.4.хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ. | 30 | 0 |
| 3 | 1.4.1.Үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулна. | 30 | 0 |
| 4 | 1.5.1.Монгол хүний онцлог, давуу тал, үнэт зүйлийг тодорхойлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ. | 0 | 0 |
| 5 | 1.5.3.Үндэсний соёл, урлаг, зан заншил, ахуй, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлж, өргөжүүлнэ | 0 | 0 |
| | **Хоёр.Хүний хөгжил** | | |
| 6 | 2.3.3.Залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирна. | 0 | 0 |
| 7 | 2.4.9.Шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацын төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулна. | 50 | 0 |
| 8 | 2.5.3.Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ. | 0 | 0 |
| | **Гурав.Амьдралын чанар ба дундаж давхарга** | | |
| 9 | 3.2.4.Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ. | 30 | 0 |
| 10 | 3.5.2.Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ. | 0 | 0 |
| | **Дөрөв.Эдийн засаг** | | |
| 11 | 4.1.3.Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлнэ. | 100 | 0 |
| 12 | 4.1.4.Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг тасралтгүй нэмэгдүүлнэ. | 100 | 0 |
| 13 | 4.1.5.Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ. | 50 | 0 |
| 14 | 4.2.6.Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. | 50 | 0 |
| 15 | 4.2.12.Улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | 30 | |
| 16 | 4.2.13.Баянтээг нүүрсний уурхайг түшиглэн 20 МВт-ийн цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөн, хөрш зэргэлдээх аймгуудын түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна. | 0 | 0 |
| | **Тав.Засаглал** | | |
| 17 | 5.2.2.Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн оновчтой зохицуулалт хийгдэнэ. | 70 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| 18 | 5.5.2.Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшүүлнэ | 0 | 0 |
| 19 | 5.5.4.Шүүх засаглалыг улс төр, бизнесийн бүлгийн ашиг сонирхлоос ангид, хараат бус байлгаж, шүүхийн үйл ажиллагаанд шударга ёсыг тогтоож, иргэдийн итгэлийг сэргээж ажиллана. | 0 | 0 |
| | **Зургаа.Ногоон хөгжил** | | |
| | --- | | |
| | **Долоо.Амар тайван, аюулгүй байдал** | | |
| | --- | | |
| | **Найм.Бүс, орон нутгийн хөгжил** | | |
| 20 | 8.2.3.Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ. | 0 | 0 |
| | **Ес.Улаанбаатар ба дагуул хот** | | |
| 21 | 9.2.1.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна. | 30 | 0 |

Хавсралт 2

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭН ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ БУУРУУЛЖ ҮНЭЛСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Зорилт, арга хэмжээ | ЗГХХГ-ын үнэлгээ, хувь | УИХТГ-ын үнэлгээ, хувь | Үнэлгээ бууруулсан шалтгаан, тайлбар |
|---|---|---|---|---|
| **НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ БОДЛОГО** | | | | |
| 1 | 1.1.1.Уран бүтээл, утга зохиолд үндэсний бахархлыг сэргээх агуулгыг тусгаж, Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзлийг сэргээнэ. | 90 | 50 | **Үр дүнг тусгаагүй.** 137.5 сая төгрөгийн санхүүжилтээр Соёлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 9-р зүйлийн 9.1.4, 9.1.8, 9.1.9, 9.11,9.12-т заасан "уран бүтээл, утга зохиол"-ын нийт 3 чиглэлээр 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хүрсэн үр дүнг тайлагнаагүй байна. Тайланд "уран бүтээл, утга зохиол"-ын онцлох 5 ажлыг тусгасан нь хууль тогтоомжид нийцэхгүй байна. |
| 2 | 1.1.2.үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно. | 90 | 50 | **Үр дүнг тусгаагүй.** 1.940 төгрөгийн санхүүжилтээр бий болгосон аялал жуулчлалын явцад шаардагдах шинэ бүтээгдэхүүн, түүний үр дүн, үр ашгийг тайланд тусгаагүй байна. Аялал жуулчлалын тухай хуулийн 4.1.3-т "аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ" гэж аялал жуулчлалын байгууллагаас жуулчинд санал болгож байгаа аяллын явцад шаардагдах бүтээгдэхүүн, үйлчилгээг;" ойлгоно гэж заасан бөгөөд ямар нэгэн арга хэмжээ /эвент/ зохион байгуулах талаар тусгаагүй байна. |
| 3 | 1.1.4.соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ. | 70 | 50 | **Үр дүнг тусгаагүй.**1/Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37-р зүйлд заасан "Соёлын өвийг хамгаалах тогтолцоо"-ны хүрээнд Засгийн газар 13-р зүйлд заасан бүрэн эрхийн хэрэгжилт, үр дүн, соёлын өвийг хамгаалах механикмыг боловсронгуй болгох саналыг тайланд тусгаагүй байна. 2/"Алсын хараа 2050" УХХБ-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны Зорилт 1.1-ийн хүрээнд 1.1.9-д заасан "Монгол Улсад түүх, соёлын өвийг сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ.", 1.1.12-т заасан "Археологийн үнэ цэнтэй дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл, ангиллыг шинэчилж, соёлын өв харгалзагч эзэнтэй болгоно." Зорилт 1.2-ын хүрээнд 1.2.4-т. заасан "Хүүхэд, залуучуудын театр, Хүүхэлдэйн театр, номын сан, кино театр, дугуйлан, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх хүүхдийн хөгжлийн төвүүдийг дэмжиж, шаардлагатай тоног төхөөрөмж, номын хөмрөг, хувцас хэрэглэлээр хангана. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.", Зорилт 1.5-ын хүрээнд 1.5.3-т заасан "Дэлхийд танигдсан оюуны болон соёлын өвийг бүтээгч хувь хүн, баг, хамт олныг дэмжиж алдаршуулах, залгамж халааг бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. Оюуны болон соёлын, биет бус өвийн бүтээлүүдийг дагасан уламжлал, ёс заншил, үндэсний онцлог бүхий брэнд үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.", 1.5.9-д заасан "Хилийн чанад дахь монгол соёлын өвийг сурвалжлан олох, судлах, нэгдсэн каталог хийх, эх орондоо эргүүлэн залах чиглэлээр бусад улс оронтой идэвхтэй хамтран ажиллана." үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг тайланд тусгаагүй байна. |
| 4 | 1.1.5.соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ. | 70 | 50 | **Үр дүнг тусгаагүй.** Соёл урлагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталснаар гарсан үр дүн, Соёлын тухай хуулийн 20.1.1-д заасан соёлын хууль тогтоомжийн биелэлт болон 20.1.2-т зааснаар соёлын төлөв байдлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланд тусгаагүй байна. |
| 5 | 1.2.2.нүүдлийн соёл, иргэншлийн судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлсэн байна. | 90 | 50 | **Үр дүнг тусгаагүй.** Биоархеологийн лабораторийг байгуулж, мэдлэгийн төвийн номын санг бүрэн тохижуулж 2024 оны 4-р сард бүрэн хүлээн авч ашиглатад оруулсан гэж тайлагнасан бөгөөд үр дүнг тусгаагүй тул "ажил тодорхой хэмжээнд эхэлсэн" гэж тооцож үнэлсэн. |
| | 1.2.4.хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ. | 30 | 0 | **Хэрэгжилтийн үр дүнг тусгаагүй.** Тайланд “Хүүхдийн номын сан”, “Хүүхэлдэйн театр”-ын төслийн зураг төсвийг баталгаажуулсан гэж тусгасан нь танилцуулгын 4-р хавсралтад заасан “Хүүхдийн соёлын өв, хөгжлийн цогцолбор” төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай" гэсэн заалттай нийцэхгүй байна. |
| | 1.3.1.Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ. | 90 | 50 | **Үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй.** Тухайлбал, Боловсролын яам Монгол судлалын хүрээлэн болон ШУТС-тай хамтран “Монгол хэлний стандарт шалгалт” төслийн үр дүнд ... хөтөлбөр, сургалт, арга зүйд шинэчлэл болсон бөгөөд ... гар утасны “ҮНДЭСНИЙ БИЧИГ” аппликейшныг туршиж, ... СӨБ, бага боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлж ... 2021-2024 оны монгол хэл, бичгийн элсэлтийн шалгалтын үр дүн нь 2121-2024 онуудад 49.0-54.0%-ийн өсөлттэй гэж тайлагнасан боловч 1.3.1 дэх арга хэмжээг нэгдмэл цогц байдлаар хэрэгжүүлэх хөтөлбө, төлөвлөгөө батлагдсан эсэх, үр дүнг тайланд тусгаагүй тул 6.2.2.3-т зааснаар "ажил тодорхой хэмжээнд эхэлсэн" гэж тооцсон. 2.Бодлогын уялдаа холбоогүй байна. Тухайлбал, ЗГҮАХ-ийн 4.4.1.5-д заасан цахим сургалт болон 2.2.1.1-д заасан "боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлэх" зорилттой уялдаа холбоогүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 1.4.1. Үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулна. | 30 | 0 | **Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.** "Монголын эзэнт гүрний өв: Бичгийн эх сурвалж ба эд өлгийн соёл"" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, хураангуй эмхтгэлийг хэвлүүлсэн гэж тайланд тусгасан бөгөөд “Үнэт зүйлийн судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж бүртгэн, мэдээллийн сан бий болгож, судалгааны эргэлтэд оруулна” гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг тайланд тусгаагүй. |
| | 1.4.2. Олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгоно. | 90 | 50 | **Үнэлгээ бууруулсан үндэслэл: "судалгааны үр дүнг нийтийн хүртээл болгох" гэсэн үр дүн, үр нөлөөг тайланд тусгаагүй, хийсэн ажлын жагсаалт бичсэн байна.** Тухайлбал, тайланг хураангуй байдлаар бичвэл: олон улсын эрдэм шинжилгээний 3 хурал, 1 форумыг зохион байгуулж, 1 суурь судалгааны нэгдсэн тайлан, монгол бичгээр эрдэм шинжилгээний 1 сэтгүүл, 9 цуврал ном, 1 гарын авлага тус тус хэвлүүлсэн тул аргачлалын 6.2.3-тзаасан "ажил тодорхой хэмжээнд эхэлсэн" гэж тооцсон. |
| | 1.5.2.Хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулна. | 70 | 50 | **Хууль тогтоомжийн биелэлтийн үр дүнг тусгаагүй.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 14.1.1-д заасан "соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, зааврын хэрэгжилт, үр дүнг тайланд тусгаагүй байна. https://abroad.mongoluv.mn цахим программд 1200 өвийн мэдээллийг оруулсан гэж тайлагнасан боловч тухайн системд нэвтэрч мэдээллийг харах эрхгүй байна. ажил тодорхой хэмжээнд эхэлсэн |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | |
| 1 | 2.1.4.Төрийн өмчит их сургуулийн засаглалыг төрөөс хараат бус болгож, эрх зүйн орчныг сайжруулан судалгааны их сургууль болгоно. | 90 | 70 | Дээд боловсролын тухай шинэчилсэн найруулгаар "Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна" гэсэн зохицуулалтыг шинээр тусгасан. Тус хуулиар зохицуулсан салбарын сайд төрийн өмчит их, дээд сургуулийн захирлын сонгон шалгаруулалт, түүний журмын талаар тайлагнасан байна. Харин "Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна" гэсэн зохицуулалтын эрх зүйн зохицуулалтын үр дүнд хэдэн сургууль байгуулсан талаарх үр дүнгийн мэдээлэл хангалтгүй байна. |
| 2 | 2.1.12.Олон улсад өрсөлдөх чадахуйц үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлнэ. | 70 | 50 | Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага болох Их Британийн Times Higher Education байгууллагаар хийлгэж, 2025 оны дэлхийн их сургуулиудын эрэмбэ, чансааг тодорхойлсноос 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зарласан дүнгээр Монгол Улсын их сургууль албан ёсоор 1501+ дугаарт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | эрэмбэлэгдсэнээр олон улсад өрсөлдөж чадахуйц үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг үр дүнд хүрсэн гэж үнэлэх боломжгүй. |
| 3 | 2.2.1.Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ. | 70 | 50 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай анхдагч хууль батлагдсанаар нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх, салбар дундын үйл ажиллагааны уялдааг хангах чиг үүрэг бүхий НЭМ-ийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор байгуулсан байна. Гэсэн хэдий ч тус зөвлөл нэг ч удаа хуралдаагүй тул нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог үр дүнтэй бэхжүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна. |
| 4 | 2.2.6.Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ. | 90 | 70 | Монгол Улсын хэмжээнд нэгдсэн нэг мэдээний санг үүсгэх, аль байгууллагаар үйлчлүүлэхээс үл хамаарч мэдээллээ хоорондоо нэг хэлээр солилцдог болох, эрүүл мэндийн мэдээллийн “Health-ESB” санг үүсгэсэн талаар түүнчлэн E-Mongolia платформоор үзүүлж байгаа үйлчилгээг холбосон талаар тайлагнасан бөгөөд өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологи нэвтрүүлсэн талаарх мэдээлэл тодорхойгүй тул үнэлгээ бууруулсан. |
| 5 | 2.3.2.Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ. | 90 | 70 | Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан ба “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлуулсан талаар тайлагнасан байна. Тус сан байгуулагдсанаар хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог хэрхэн нэмэгдүүлсэн үр дүнгийн мэдээлэл хангалтгүй тул 100 хувь үр дүн гарсан гэж үзэх үндэслэлгүй байна. |
| 6 | 2.3.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана. | 90 | 50 | Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх зорилготой холбогдох хуулийн төсөл боловсруулалтын шатанд байгаа тул ХБИ-ний хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдах хууль эрх зүйн орчин бүрдээгүй гэж үзэж үнэлгээ бууруулсан. |
| 7 | 2.3.5.Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно. | 100 | 90 | Эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалын дагуу үнэлсэн. /Аргачлалын 6.2.2/ |
| 8 | 2.4.1.Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, эрдэм шинжилгээ, судалгаанд | 100 | 90 | Эрдэм шинжилгээний байгууллагын чадавхыг бэхжүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох зорилгоор төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийн жагсаалтыг баталсан бөгөөд судалгааны үндсэн чиглэлд 2023 онд 900.0 сая төгрөг, 2024 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | зарцуулах төсвийн зардлыг үе шаттай нэмэгдүүлнэ. | | | онд 1.1 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалын дагуу үнэлсэн. /Аргачлалын 6.2.2/ |
| 9 | 2.4.2.Шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлого хэрэгжүүлж, эрдэм, шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлнэ. | 100 | 90 | Шинжлэх ухаан, технологи, инновацийн өндөр мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, үндэсний чадавхийг бэхжүүлэх, тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр салбар дундын судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор Шинжлэх ухааны академийн их сургуулийг ахисан түвшний дээд боловсролын сургалтын байгууллага (UMAS) статустайгаар байгуулснаар шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах тогтолцоо бүрдэх эхний томоохон шийдэл болсон байна. Хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй тул аргачлалд /6.2.2/-д нийцүүлэн үнэлсэн. |
| 10 | 2.4.4.Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг татварын бодлого, эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэлт хийгдэнэ. | 100 | 70 | Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийг санхүү, татварын бодлогоор дэмжих эрх зүйн орчин бий болсон гэж тайлагнасан хэдий ч эдийн засгийн эргэлтэд орсон шинэ патентын талаарх мэдээлэл хангалтгүй байгаа тул 100 хувь үр дүн гарсан гэж үзэх үндэслэлгүй байна. |
| 11 | 2.4.5.Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд бүтцийг бий болгож, төрөлжсөн нээлттэй лабораторийг байгуулж, шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг ашиглалтад оруулна. | 70 | 50 | Шинжлэх ухаан, технологи, инновацын бүрэн ашиглалтад орсон дэд бүтэц байхгүй. Түүнчлэн Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг барих төсвийн саналыг 2025 оны төсөвт тусгахаар Сангийн яаманд хүргүүлсэн тул тус арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэх үндэслэлгүй байна. |
| 12 | 2.4.7.Шинжлэх ухаан, технологи, инновацын статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно. | 70 | 50 | Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээний албан ёсны болон захиргааны маягтыг батлуулах чиглэлд хийсэн ажлын талаар тайлагнасан бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох талаар хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнаагүй, мэдээлэл дутуу байгаа тул арга хэмжээг бүрэн хэрэгжсэн гэж үзэх үндэслэлгүй байна. |
| 13 | 2.4.8.Хэмжил зүйн лабораторийг олон улсын жишигт хүргэсэн байна. | 70 | 50 | Хийн тоолуур шалгах суурин ажлын эталон төхөөрөмж худалдан авч, хийн тоолуур шалгах лабораторийг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн байгуулсан талаар тайлагнасан ба хэмжил зүйн лабораторийг иж бүрнээр нь олон улсын жишигт хүргэсэн мэдээлэл байхгүй тул үнэлгээ бууруулсан. |
| 14 | 2.4.9.Шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацын төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулна. | 50 | 0 | Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн мэдээний албан ёсны болон захиргааны маягтыг баталсантай холбоотой хийсэн ажлыг тайлагнасан байх бөгөөд шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг хэрхэн ашиглаж, хэрэглээнд нэвтрүүлж байгаа талаар зорилт, арга хэмжээний хүрээнд хийсэн ажлыг тайлагнаагүй байна. Арга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хэмжээний хэрэгжилтийг буруу тайлагнасан тул хэрэгжилтийг 0 хувиар үнэлсэн. |
| 15 | 2.5.1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болж, хүнсний аюулгүй байдал хангагдана. | 70 | 50 | "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд хийсэн ажлыг болон холбогдох стандартыг батлуулсан талаар тайлагнасан бөгөөд хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох ямар ямар чадвар бүрдсэн талаарх үр дүнгийн мэдээлэл дутуу тул хэрэгжилтийн хувийг буулган үнэлсэн. |
| 16 | 2.6.2.Ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 90 | 70 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа /хөтөлбөр/-г батлуулсан талаар тайлагнасан бөгөөд ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэх чиглэлд хийсэн ажил, үр дүнг тайлагнаагүй тул бүрэн хэрэгжсэн гэж үндэслэлгүй байна. |
| 17 | 2.6.3.Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 90 | 70 | Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг батлуулж, холбогдох сургалтыг хийсэн талаар тайлагнасан. Мөн улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн, ижил стандарт бүхий “Job center” төвүүдийг байгуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод эхний төвүүд үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Харин оюуны хөдөлмөрт чиглэсэн арга хэмжээний талаар тайлагнаагүй тул үнэлгээ бууруулсан. |
| 18 | 2.7.3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ. | 100 | 70 | 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй гадаадын иргэний талаар дурдаад зохистой түвшинг даваагүй талаар тайлагнасан байна. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшин хэд байх ёстой талаар түүнчлэн хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх чиглэлд хийсэн ажлын үр дүнг тайлагнаагүй тул хэрэгжилтийг үнэлгээ бууруулсан. |
| **ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | |
| 1 | 3.1.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ. | 90.0 | 70 | ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй |
| 2 | 3.1.3.Нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээ ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно. | 90.0 | 30 | ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй |
| 3 | 3.1.4.Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад | 90.0 | 70 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ. | | | |
| 4 | 3.1.5.Нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. | 100.0 | 90 | ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй |
| 5 | 3.2.1.Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоог бий болгоно. | 50.0 | 30 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 6 | 3.2.4.Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ. | 30.0 | 0 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 7 | 3.3.1.Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ. | 90.0 | 30 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 8 | 3.3.2.Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшинө. | 70.0 | 50 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 9 | 3.3.4.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ. | 70 | 50 | Аргачлалын дагуу үнэлэхэд үр дүн хангалтгүй |
| 10 | 3.4.1.Зорилтот санхүүжилт, хөнгөлөлт, хүртээмжтэй үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ. | 90.0 | 50 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 11 | 3.4.2.Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна. | 70.0 | 30 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 12 | 3.5.3.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ. | 100.0 | 90 | ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй |
| 13 | 3.6.1.Газрын харилцаа, хот байгуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтоосон байна. | 70.0 | 30 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 14 | 3.6.3.Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий | 100.0 | 90 | ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоог бүрдүүлнэ. | | | |
| 15 | 3.6.5.Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлнэ. | 90.0 | 30 | Арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнасан |
| 16 | 3.6.6.Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй суурин тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ. | 100.0 | 90 | ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу үнэлээгүй |
| **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ** | | | | |
| 1 | 4.1.1.Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөлийг бүрдүүлнэ. | 70 | 30 | Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоо хэрхэн сайжирч, ямар үр дүн гарсан нь тодорхойгүй. Өрийн дарамт буураагүй, Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн эсэх тодорхойгүй 2.БНСУ, ТУ, БНТУ-уудтай хэлэлцээр хийх гэж оролдсон. Үр дүн гараагүй байгаа |
| 2 | 4.1.2.Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болгоно. | 70 | 30 | Бодлогын зорилго, зорилтдоо бүрэн хүрээгүй, үр дүн тодорхой бус байна. |
| 3 | 4.1.3.Гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлнэ. | 100 | 0 | Гадаад валютын албан нөөц нэмэгдээгүй |
| 4 | 4.1.4.Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг тасралтгүй нэмэгдүүлнэ. | 100 | 0 | Ажил эрхлэлтийн түвшин тасралтгүй хэдэн хувиар нэмэгдсэн талаар тодорхой тайлагнаагүй. ҮСХ-ны албан ёсны цахим хуудсаас харахад ажил эрхлэлт нэмэгдээгүй байна. |
| 5 | 4.1.5.Бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлнэ. | 50 | 0 | Хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг бүрэн, тодорхойгүй. Иргэдийн худалдан авах чадвар хэдэн хувиар нэмэгдсэнийг тооцож тайлагнаагүй. |
| 6 | 4.1.6.Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ. | 90 | 30 | Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг эцэслэн батлуулаагүй. |
| 7 | 4.1.7.Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ. | 70 | 30 | Бэлтгэл ажил хийгдсэн. Үр дүн гарч эхлээгүй. |
| 8 | 4.2.1.Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлнэ. | 50 | 30 | Боловсруулалтын түвшин хэдэн хувиар нэмэгдсэн нь тодорхойгүй. Үр дүнгийн талаар тайлагнаагүй |
| 9 | 4.2.2.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ. | 50 | 30 | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг болон малын гаралтай бүтээгдэхүүний экспорт хэрхэн нэмэгдсэн эсэх тодорхойгүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | 4.2.3.Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | 100 | 30 | Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал хэрхэн хөгжиж олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвар хэдэн хувиар дээшилсэн зэрэг үр дүн тодорхойгүй |
| 11 | 4.2.4.Бүтээлч үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн, архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурь тавигдана. | 100 | 90 | Тодорхой үр дүн гарсан. |
| 12 | 4.2.5.Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ. | 90 | 50 | Мэдээлэл технологийн салбарын эдийн засагт хэрхэн нөлөөлж, ямар үр дүн гарч байгаа талаар тодорхойгүй |
| 13 | 4.2.6.Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ. | 50 | 0 | Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн. Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлээгүй байна |
| 14 | 4.2.8.Цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана. | 70 | 50 | Цахилгаан эрчим хүсээр дотоодын хэрэгцээг бүрэн хангагдаагүй |
| 15 | 4.2.11.Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ. | 70 | 50 | Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн. |
| 16 | 4.2.12.Улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | 30 | 0 | Бэлтгэл ажил эхэлсэн |
| 17 | 4.2.14.Завхан, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний дутагдлыг арилгах зорилгоор шаардлагатай агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийн шинэчлэл, барилгын ажлыг хэрэгжүүлнэ. | 90 | 70 | Үр дүн тодорхой хэмжээнд гарч эхэлсэн |
| 18 | 4.2.16.Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлнэ. | 90 | 50 | Үр дүн гарч эхэлсэн. Эрчим хүчний дотоодын хэрэгцээ бүрэн хангагдаагүй |
| 19 | 4.3.2.Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлнэ. | 50 | 30 | Бэлтгэл ажил дууссан. Боловсруулалтын шатанд байгаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 20 | 4.3.3.Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааны хүрээг тэлнэ. | 90 | 30 | Бичил санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны хүрээг хэрхэн тэлсэн нь тодорхойгүй |
| 21 | 4.3.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно. | 100 | 70 | Үр дүн гарч эхэлсэн. Тогтолцоо хэрхэн боловсронгуй болсон талаар тодорхойгүй |
| 22 | 4.4.1.Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ. | 70 | 30 | Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх талаар бэлтгэл ажил хийгдсэн. Үр дүн гарч эхлээгүй |
| 23 | 4.4.2.Гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлнэ. | 70 | 50 | Гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх ажил тодорхой хэмжээнд эхэлсэн. Үр дүн бүрэн гараагүй |
| 24 | 4.5.1.Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 90 | 30 | Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэл хөгжүүлэх бэлтгэл ажил эхэлсэн |
| **ТАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | |
| 1 | 5.2.1.Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах шинэчлэл хийгдэж эхэлнэ. | 70 | 50 | Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах зорилгоор холбогдох судалгааг хийж, бусад улсын туршлагыг судалж, Төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж, холбогдох систем хөгжүүлэх ажил хийгдэж байгаа тухай тайлагнасан байна. Эдгээр ажлын дараа Төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах шинэчлэл хийгдэж эхлэх тул аргачлалд нийцүүлэн боловсруулалтын ажил хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн гэж үзэж хэрэгжилтийг 50 хувиар үнэллээ. |
| 2 | 5.2.2.Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн оновчтой зохицуулалт хийгдэнэ. | 70 | 0 | Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн оновчтой зохицуулалт хийгдсэн байхаар тусгасан боловч тайлагналт хангалтгүй, тодорхой бус, үр дүн байхгүй.<br>Хэрэгжилтийг “БНСУ-ын Засаг захиргаа, дотоод хэргийн яамнаас гаргасан Чиг үүргийн талаар “Төрийн урлахуй” сэдвээр материал боловсруулсан. Мөн ”Байгууллагыг шинжлэх ухааны үндэслэлтэй, үр дүнтэй оношлох гарын авлага”-г монгол хэл дээр бэлтгэн гаргасан” гэж тайлагнасан. |
| 3 | 5.2.3.Гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ. | 100 | 90 | 2023 оны тоо мэдээ тайлагнасан бөгөөд гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд хийгдсэн ажил, үр дүнг тайлагнаагүй байна. “Цахим нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан гадаадын хөрөнгө оруулагчдад төрийн 7 байгууллагын 17 үйлчилгээг үзүүлсэн гэж тайлагнан 17 үйлчилгээг жагсаасан. |
| 4 | 5.4.3.Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ. | 30 | 50 | Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд УИХ-аас 2023 оны 5 дугаар сард “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг батлапж, ТАЗ-ийн дэргэд 9 гишүүнтэй Ёс зүйн хороо |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | байгуулагдаж, улсын хэмжээнд төрийн албанд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиг үүрэг бүхий тогтолцоо, нийт төрийн байгууллагад “Ёс зүйн дэд хороо” байгуулан ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн бөгөөд Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг 2024 оны 4 дүгээр сард баталж, ёс зүйн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан тул тодорхой үр дүн гарсан гэж үзэж хэрэгжилтийг 50 хувиар үнэллээ. |
| 5 | 5.4.5.Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ. | 50 | 30 | Төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлэх асуудлын хүрээнд хийсэн ажлаа тайлагнаагүй. Энэ хүрээнд “Төрийн албаны үйл ажиллагааны стандартад тавих ерөнхий шаардлага MNS ... 2024" үндэсний стандартын төслийг боловсруулж, батлуулахаар Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн бөгөөд. Төрийн үйлчилгээний стандартчиллын техникийн хороо стандартын төслийг хэлэлцэхээр бэлтгэж байгаа тухайд тайлагнасан, тодорхой үр дүн гараагүй байна. |
| 6 | 5.4.7.Орон нутагт томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулна. | 50 | 30 | Арга хэмжээний хүрээнд бүрэн тайлагнаагүй, тогтоол батлагдсанаар гарсан үр дүн, нийгмийн ямар асуудлыг сайжруулсан талаар тайлагналт хангалтгүй байна. |
| **ЗУРГАА.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | |
| 1 | 6.1.2.Монгол орны ургамал газарзүйн 4-өөс доошгүй тойргийн ашиглалтад өртөмтгий 200 зүйл ургамал, 10 зүйл амьтны тархац нөөцийг тогтоож, Олон улсын улаан дансны шалгуураар 600 зүйл амьтан, ургамлыг нарийвчлан үнэлж, ховордлын шалтгааныг тодорхойлно. | 90 | 70 | Зорилтот түвшинд хүрээгүй буюу тухайлбал, Олон улсын улаан дансны шалгуураар 600 зүйл амьтан, ургамлыг нарийвчлан үнэлж, ховордлын шалтгааныг тодорхойлохоос 233 зүйл амьтны улаан дансны үнэлгээг хийсэн. Мөн үр дүн тодорхойгүй, тайлагналт хангалтгүй. |
| 2 | 6.2.4.Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ. | 100 | 90 | Тайлагналт хангалтгүй, тухайлбал хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барих талаар тайлагнаагүй. |
| 3 | 6.3.2.Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхэлнэ. | 70 | 50 | Зорилтот түвшинд бүрэн хүрээгүй. Томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхлээгүй. |
| 4 | 6.3.3.Нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангасан байна. | 50 | 30 | Тайлагналт хангалтгүй, Нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангасан байх зорилт тавьсан. Гэвч хэдэн хувийг хангаж байгаа талаар тайлагнаагүй, тодорхойгүй байна. Судалгааны |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ажил хийсэн талаар тайлагнасан боловч үр дүн тодорхой бус, тайлагнаагүй байна. |
| 5 | 6.4.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан үндэсний ногоон санхүүгийн корпорац (НСК) байгуулан ногоон эдийн засгийг дэмжих төсөл, хөтөлбөрийн санхүүгийн шинэ эх үүсвэрийг бүрдүүлнэ. | 70 | 50 | Гүйцэтгэл, үр дүн бүрэн хангагдаагүй. Үндэсний ногоон санхүүгийн корпораци НСК байгуулагдаагүй бэлтгэл, боловсруулалтын шатны ажил хийгдэж байгаа тул аргачлалд нийцүүлэн үнэлэв. |
| 6 | 6.4.7.Аймгийн төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна. | 70 | 50 | Зорилтот түвшинд хүрээгүй, тайлагналт болон үр дүн хангалтгүй, тодорхойгүй байна. тухайлбал, тайланд зарим аймаг, сумдын төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэсэн талаар тайлагнаж, хог хаягдлын менежментийн g 9206-mon төсөл"-ийн хүрээнд 4 аймгийн хатуу хог хаягдлын асуудлыг шийдсэн байна. |
| **ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ** | | | | |
| 1 | 7.1.1.Мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, алба хаагчдын амьдрах нөхцөл шинэчлэгдэж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувийг нэмэгдүүлнэ. | 70 | 50 | **Дутуу тайлагнасан.** "мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх" болон "хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувийг нэмэгдүүлэх" хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгаагүй. |
| 2 | 7.1.2.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ. | 70 | 50 | **Зарим төлөвлөгөөг батлаагүй.** Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг батлаагүй байна. |
| 3 | 7.1.3.Энхийг дэмжих ажиллагаа болон улс орны стратегийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ. | 90 | 70 | **Үр дүнг тусгаагүй.** Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, өсөлт, бууралтын харьцуулсан судалгаанд үндэслээгүй, иргүүлсэн тайланг хуулбарлан бичжээ. |
| 4 | 7.2.1.Хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг боловсронгуй болгоно. | 100 | 70 | **Үр дүнг тусгаагүй.** Хилийн алба хооронд 2021-2024 онд хамтран ажиллах хөтөлбөр, ажлын график төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг тусгаагүй. |
| 5 | 7.2.3.Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдал дээшилнэ. | 90 | 70 | **Үр дүнг тусгаагүй.** |
| 6 | 7.3.1.Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, | 70 | 50 | **Дутуу тайлагнасан.** "хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлэх" ажлын явцыг тайланд тусгаагүй. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. | | | |
| 7 | 7.3.3.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлнэ. | 90 | 70 | **Үр дүнг тусгаагүй.** Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй. |
| 8 | 7.3.5.Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлж, архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 90 | 70 | **Үр дүнг тусгаагүй.** Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 72 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан байгуулах, сангийн үйл ажиллагааны журам, Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан 20 цагдаагийн байгууллага /Нийслэлийн 4 дүүрэг, 16 аймаг/-аас баталсан хөтөлбөр, төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг тусгаагүй байна. |
| 9 | 7.3.6.Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ. | 90 | 70 | **Үр дүнг тусгаагүй.** Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй. |
| 10 | 7.4.1.Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна. | 100 | 70 | Гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа гэж тооцсон. |
| 11 | 7.4.2.Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлнэ. | 90 | 50 | Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн байна. |
| 12 | 7.4.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлнэ. | 70 | 50 | Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн байна. |
| 13 | 7.4.4.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно. | 70 | 30 | **ХЗДХЯ-аас бусад байгууллагын мэдээллийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.** Засгийн газрын "Хөтөлбөр батлах тухай" 2022.07.005-ны өдрийн 265 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр" /2022-2030 он/--ийн 5.7-д "Үндэсний зөвлөл нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн тайланг жил бүрийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт хүргүүлж танилцуулна" гэж заасан заалтын хэрэгжилтийг тус тайлангийн 4.4.1.10 дахь зорилтын хүрээнд тайлагнаагүй байна. Түүнчлэн ХЗДХЯ-аас бусад байгууллагын мэдээллийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна. Түүнчлэн "... биелэлтийн тайланг жил бүрийн эхний хагас жилд багтаан Засгийн газарт хүргүүлж танилцуулна" гэсэн заалтыг цаглаврын хувьд нийцүүлэх шаардлагатайг харуулж байна. |
| 14 | 7.4.5.Мал хулгайлах гэмт хэргийг бууруулна. | 100 | 50 | Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | 7.4.6.Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. | 90 | 70 | Гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байна. |
| 16 | 7.4.7.Хууль сахиулах байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ. | 100 | 70 | **Үр дүнг тусгаагүй.** mail.e-mongolia болон “edoc” программд бүртгэсэн өргөдөл, гомдлийн шийдвэрлэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна. |
| 17 | 7.5.1.Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ. | 100 | 50 | Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн байна. |
| 18 | 7.5.2.Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавх дээшилсэн байна. | 70 | 50 | Ажил тодорхой хэмжээнд эхэлсэн байна. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв”-д шаардлагатай программ хангамж, тоног төхөөрөмж худалдан авах ажлын даалгаврыг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. |
| **НАЙМ.БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ** | | | | |
| **Үнэлгээ бууруулсан арга хэмжээ байхгүй** | | | | |
| | **ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ** | | | |
| 1 | 9.2.1.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулна. | 30 | 0 | 1212.mn сайтаас mp2.5, 10 статистикийг 2019-2024 оноор харьцуулж харахад агаарын бохирдол буураагүй бага зэргийн өсөлттэй байна. НЗДТГ-аас тайлагнасан тоо мэдээллийг нягтлах шаардлагатай байна.<br><br>2000 тэмдэгтэд багтаан тайлагнаагүй. |
| 2 | 9.2.2.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болгоно. | 70 | 30 | хуульд холбогдох заалт тусгагдсан боловч, хэрэгжиж эхлээгүй, холбогдох журмууд батлагдаагүй байна |
| 3 | 9.2.4.Олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ. | 90 | 70 | Нийт талбай, замын сүлжээтэй харьцуулахад цаашид хийгдэх боломжтой газар олон байгаа.<br><br>Хэт амархан зорилт тусгагдсан. |

---oOo---